



**ОРХОН АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2024 оны 02 дугаар сарын 29

Дугаар 18/01

Баян-Өндөр сум

Хуралдааны дэг батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.2, 46.9 дэх хэсэг, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсгийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ НЬ:

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ээлжит XVIII хуралдааны дэгийг хавсралтаар баталсугай.

2. Хуралдааны дэгийг мөрдөж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчид, Хуралдаанд оролцогчдод үүрэг болгосугай.

ДАРГА



Д. МӨНХБАТ

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024
оны 02 дугаар сарын 29-ний өдрийн Ээлжит XVIII
хуралдааны 18/01 дүгээр тогтоолын хавсралт

АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ЭЭЛЖИТ XVIII ХУРАЛДААНЫ ДЭГ

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 8 дахь удаагийн сонгуулийн Ээлжит XVIII хуралдаан 2024 оны 02 дугаар сарын 29-ний өдрийн 09:00 цагт аймгийн Нутгийн удирдлагын ордны А.Амарын нэрэмжит их танхимд эхэлнэ.

Хурлын хуралдаанд аймгийн Засаг даргын орлогч, аймгийн ИТХ-ын Нарийн бичгийн дарга, аймгийн ЗДТГ-ын дарга, аймгийн ИТХ-ын болон ЗДТГ-ын хэлтсийн дарга нар, холбогдох агентлагийн удирдлага, мэргэжилтнүүд, “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын хэлтсийн дарга, холбогдох мэргэжилтнүүд, хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтнууд оролцоно.

1.Хуралдааны хэлэлцэх асуудлын төлөвлөгөөний төслийг танилцуулж олонхын саналаар батална.

2.Хуралдааны хэлэлцэх асуудлын танилцуулга 5-15 минут байна.

3.Аймгийн ИТХ-ын Ээлжит XVIII хуралдааны дэд даргад Төлөөлөгчдөөс нэр дэвшүүлж санал хураалтаар сонгуулна.

4.Хэлэлцэж байгаа асуудлаар гарах шийдвэрийн төслийг эцэслэн боловсруулах зорилгоор Редакцын комиссыг 3 хүртэлх Төлөөлөгчдийн бүрэлдэхүүнтэй байгуулж ажиллуулна. Редакцын комиссын анхдугаар хурлыг хуралдааны удирдлагын зүгээс хийлгэж, даргыг сонгуулан хуралдаанд мэдэгдэж, ажиллахад нь зориулж бэлтгэсэн хавтсыг холбогдох материалын хамт хүлээлгэн өгч, тусгайлан бэлдсэн байранд урьж суулган ажилд нь оруулна.

5.Утга агуулгын болон ажлын уялдаа холбоог харгалзан тухайн асуудлыг шаардлагатай бол нэг багц асуудал болгон хэлэлцэж, асуулт хариулт, санал шүүмжлэлийг нэг мөр явуулж болно.

6.Хуралдаанд оролцож байгаа Төлөөлөгчдийн ирцийг mlsp.mn программаар бүртгэнэ.

7.Тухайн асуудлаар асуулт асуух, санал хэлэх Төлөөлөгчдийн нэрсийг хуралдааны удирдлагын зүгээс Mlsp.mn программаар урьдчилан авч дараалалд оруулна. Төлөөлөгчид тус программын санал гэсэн цэс дээр даран өөрийн нэрээ урьдчилан өгнө.

8.Хүндэтгэн үзэхээс бусад шалтгаанаар Хурлын Төлөөлөгч зориудаар хуралдаанд оролцохгүй байх буюу түүнийг орхиж гарахыг хориглоно. Хуралдаанд зориудаар оролцоогүй буюу орхиж гарсан тохиолдолд хуралдаанд оролцож эсрэг санал өгсөнд тооцож санал хураалт явуулна.

9.Тухайн хэлэлцэж байгаа асуудлаар үг хэлэх хугацаа хүн тус бүрд эхний удаа 3 хүртэл минут, хоёр дахь удаа 1 хүртэл минут байна.

10.Тухайн хэлэлцэж байгаа асуудлаар эцсийн шийдвэр гаргах, асуулт, хариулт, санал, шүүмжлэлийг таслахдаа санал хураалт явуулж олонхын саналаар шийдвэрлэнэ.

11.Хэлэлцэж байгаа асуудлаар цөөнх болсон Төлөөлөгчдийн үндэслэл, саналыг сонсож, дахин нэг удаа санал хураалт явуулж болно.

12.Асуулт асуух, үг хэлэх, санал шүүмжлэл гаргах зөвшөөрлийг хуралдааны удирдлага олгож, тогтоосон хугацааг баримтална.

13.Санал, шүүмжлэлийг хуралдааны удирдлагад бичгээр өгч болно. Бичгээр өгсөн санал шүүмжлэлийг хуралдааны удирдлага танилцуулах бөгөөд шаардлагатай гэж үзвэл Редакцын комисст шилжүүлнэ.

14.Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан намын бүлэг завсарлага авч болох бөгөөд завсарлагын хугацаа эхний удаа 1 цаг, хоёр дахь удаа 30 минут хүртэл байна. Завсарлага авснаас хойш бүлгээс тухайн асуудалд нэгдсэн байр суурь илэрхийлж хуралдаанд оролцоно.

15.Намын бүлэгт олгосон завсарлагын хугацаа сунгах шаардлага гарвал хуралдаанаар шийдвэрлэх бөгөөд тогтоосон хугацааг чанд баримтална.

16.Аймгийн ИТХ-ын Төлөөлөгч нь хуралдаанаар хэлэлцэх асуудал болон шийдвэрийн төслийг боловсруулах, шийдвэр гаргахад оролцох асуудлаар ашиг сонирхлын зөрчилтэй буюу зөрчил үүсэж болзошгүй гэж үзвэл аймгийн ИТХ-ын дарга болон аймгийн ИТХ-ын эрх бүхий албан тушаалтанд мэдэгдэл гаргана.

17.Хуралдааныг 2 цаг тутам 15 минутын завсарлагаатайгаар явуулна.

18.Өдрийн их завсарлага 1 цаг байна.

19.Хуралдаан тухайн ажлын өдөр багтахгүй бол үргэлжлүүлэх аль эсвэл дараачийн өдөр шилжүүлэх асуудлыг санал хураалт явуулж олонхын саналаар шийдвэрлэнэ.

20.Хуралдааны мэдээллийг орон нутгийн "NB HD" телевиз шууд дамжуулна. Мөн орон нутгийн бусад телевиз, сайт зэрэг хэвлэл мэдээллийн байгууллагуудаар дамжуулан иргэдэд хүргэх боломжоор ханган ажиллана.

21.Хуралдааны үед иргэдтэй харилцах 7035-0494 дугаарын утас ажиллана. Иргэдтэй харилцах утаснаас ирүүлсэн хувь хүний нэр төртэй холбоотойгоос бусад хэлэлцэж буй асуудалтай холбоотой саналыг багцлан хуралдаанд танилцуулж, шаардлагатай бол холбогдох албан тушаалтнаар хариу тайлбар хэлүүлнэ. Харин хэлэлцэж буй асуудалтай хамааралгүй иргэдийн ирүүлсэн хүсэлт, саналыг хуралдаанд танилцуулахгүйгээр шууд холбогдох албан тушаалтанд хүргүүлнэ.

22.Хуралдааны дарга хэлэлцэх асуудлыг хуралдааны дэгийн дагуу амжилттай явагдаж өндөрлөснийг дүгнэж, хуралдааныг хаасныг мэдэгдэнэ.

23.Хуралдааны тэмдэглэлийг аймгийн ИТХ-ын Ажлын албаны хурлын зохион байгуулалт, хууль эрх зүй хариуцсан ахлах мэргэжилтэн хөтөлнө.

**АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ЭЭЛЖИТ XVIII ХУРАЛДААН**